

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 147.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Хөдөлмөрийн арбитрын дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

2. Хөдөлмөрийн арбитрын үйл ажиллагаатай холбоотой зардлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцаас санхүүжүүлж, цаашид жил бүр улсын төсөвт тусгаж байхыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.

3.“Хөдөлмөрийн арбитрын дүрэм”-ийг 2022 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

ГАРЫН ҮСЭГ

ХӨДӨЛМӨРИЙН АРБИТРЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрэм нь хөдөлмөрийн арбитрчийг сонгох, нэрсийн жагсаалт гаргах, томилох, хөдөлмөрийн сонирхлын хамтын маргааныг (цаашид “сонирхлын маргаан” гэх) хөдөлмөрийн арбитраар хэлэлцэн шийдвэрлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Хөдөлмөрийн арбитрын бүрэлдэхүүн, хөдөлмөрийн арбитрч сонирхлын маргааныг шийдвэрлэх үйл ажиллагаандаа хөдөлмөрийн хууль тогтоомж болон энэ дүрмийг мөрдөнө.

Хоёр.Арбитрчийн нэрсийн жагсаалт, түүнийг сонгох, томилох

2.1.Аймаг, нийслэлийн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо /цаашид “Аймаг, нийслэлийн хороо” гэх/ нь хөдөлмөрийн арбитрчаар дараах шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж, бүртгэнэ:

2.1.1.дээд боловсрол эзэмшсэн;

2.1.2.хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэгтэй, хөдөлмөрийн асуудлаар мэргэшсэн;

2.1.3.асуудалд дүн шинжилгээ хийх, шийдвэрлэх ур чадвартай;

2.1.4.хараат бус, төвийг сахисан байр суурьтай, алагчлалгүй, шударга хандах чадвартай байх.

2.2.Аймаг, нийслэлийн хороо нь хөдөлмөрийн арбитрчаар ажиллах иргэнийг дараах байдлаар сонгон шалгаруулна:

2.2.1.олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр зарлах;

2.2.2.хөдөлмөрийн асуудлаар мэргэшсэн иргэнийг сонгож, санал тавих.

2.3.Аймаг, нийслэлийн хороо нь энэ дүрэмд заасан шаардлага хангасан, хөдөлмөрийн арбитрчаар ажиллах 9-өөс доошгүй иргэний нэрсийн жагсаалт, холбогдох бичиг баримтыг нэгтгэн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хороо /цаашид “үндэсний хороо” гэх /-нд хүргүүлнэ.

2.4.Үндэсний хороо нь аймаг, нийслэлийн хорооноос ирүүлсэн хөдөлмөрийн арбитрчдын нэрсийн жагсаалтыг баталж, арбитрчаар томилох тухай шийдвэрийг гарган, аймаг, нийслэлийн хороонд хүргүүлнэ.

2.5.Хөдөлмөрийн арбитрч хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан зарчим, хөдөлмөрийн арбитрчийн ёс зүйн дүрмийг 2 ба түүнээс дээш удаа зөрчсөн, эсхүл өөрөө арбитрчаас чөлөөлөх хүсэлт гаргасан, эсхүл хөдөлмөрийн арбитрч нас барсан, хууль тогтоомжид заасан бусад үндэслэл үүссэн тохиолдолд аймаг, нийслэлийн хорооны саналыг үндэслэн үндэсний хороо хөдөлмөрийн арбитрчаас чөлөөлөх шийдвэр гаргана.

2.6.Хөдөлмөрийн арбитрчийн сул орон тоо гарсан тохиолдолд энэ дүрмийн 2.1-д заасан шаардлагыг хангасан иргэнийг аймаг, нийслэлийн саналаар үндэсний хороо томилно.

2.7.Хөдөлмөрийн зуучлагчийн нэрсийн жагсаалтад багтсан иргэнийг хөдөлмөрийн арбитрчаар томилж болно. Тухайн маргаанд хөдөлмөрийн зуучлагчаар болон хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан бол уг маргаан шийдвэрлэх арбитрын бүрэлдэхүүнд түүнийг хөдөлмөрийн арбитрчаар томилохгүй.

Гурав.Сонирхлын маргаан шийдвэрлэх хөдөлмөрийн арбитрын үйл ажиллагаа

3.1. Сонирхлын маргаан маргалдагч талууд Хөдөлмөрийн тухай хуулийн 151.1-д заасны дагуу хөдөлмөрийн арбитраар шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргана.

3.2.Хөдөлмөрийн тухай хуулийн 28.1-д заасан хүн амд нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагад үүссэн сонирхлын маргааныг хөдөлмөрийн зуучлагчийн дэмжлэгтэйгээр маргааныг зохицуулах үе шатыг алгасаж, хөдөлмөрийн арбитраар шийдвэрлүүлэхээр маргалдагч тал аймаг, нийслэлийн хороонд хандана.

3.3.Хүсэлт хүлээн авсан аймаг, нийслэлийн хороо Хөдөлмөрийн тухай хуулийн 151.2-т заасны дагуу хуульд заасан хугацаанд хөдөлмөрийн арбитрыг байгуулж, нэн даруй хуралдана.

3.4. Хөдөлмөрийн арбитрын бүрэлдэхүүнд томилогдсон арбитрч тухайн маргаантай танилцах бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй гэж үзвэл энэ тухай аймаг, нийслэлийн хороонд мэдэгдэж уг маргаанд оролцохоос татгалзах үүрэгтэй. Ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй болон хүндэтгэн үзэх бусад шалтгаан бий болсон тохиолдолд хөдөлмөрийн арбитрчийг энэ дүрмийн дагуу нөхөн томилно.

3.5.Хөдөлмөрийн арбитрч нь аливаа ашиг сонирхлын зөрчлийг томилогдохоосоо өмнө болон дараа нь, эсхүл ийм зөрчлийн тухай мэдсэн даруйд нь мэдэгдээгүй, нуун дарагдуулсан бол хөдөлмөрийн арбитрчийн ёс зүйн дүрмийн дагуу шийдвэрлэнэ.

3.6.Тухайн сонирхлын маргааны маргалдагч талуудын төлөөлөгчийг хөдөлмөрийн арбитрын бүрэлдэхүүнд оруулахгүй.

3.7.Аймаг, нийслэлийн хороо нь маргалдагч талуудад хөдөлмөрийн арбитр байгуулсан тухай шийдвэрээ албан бичгээр мэдэгдэнэ.

3.8.Энэ дүрмийн 3.3-т заасан хугацаанаас хойш ажлын гурван өдрийн дотор хөдөлмөрийн арбитрын бүрэлдэхүүн сонирхлын маргаан шийдвэрлэх үйл ажиллагааг эхлүүлнэ.

3.9.Сонирхлын маргаан шийдвэрлэх хөдөлмөрийн арбитрын ажиллагаа нь хуралдаан хэлбэртэй байна.

3.10.Хөдөлмөрийн арбитрчид сонирхлын маргаантай холбоотой баримт бичигтэй танилцсаны дараа хөдөлмөрийн арбитрын хуралдаан хийх тов болон хуралдаан болох газрын байршлын талаар маргалдагч талуудад мэдэгдэж, талуудыг хуралдаанд оролцох боломжоор хангана.

3.11.Сонирхлын маргааныг хөдөлмөрийн арбитраар шийдвэрлэх хуралдаанд хөдөлмөрийн арбитр бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцоно.

3.12.Хөдөлмөрийн арбитрыг байгуулснаас хойш ажлын гурван өдрийн дотор сонирхлын маргааныг шийдвэрлэхтэй холбоотойгоор хөдөлмөрийн арбитрч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.12.1.сонирхлын маргааны агуулга, холбогдох бичиг баримт, хөдөлмөрийн зуучлагчийн тэмдэглэл, маргалдагч талуудын ирүүлсэн бичиг баримттай танилцах;

3.12.2.маргалдагч талууд буюу тэдний төлөөлөгчөөс тайлбар, тодруулга авах, шаардлагатай бол нэмэлт бичиг баримт гаргуулах;

3.12.3.хөдөлмөрийн арбитрчдын олонх нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд сонирхлын маргааны нөхцөл байдалтай холбоотой асуудлыг нарийвчлан шинжилж тогтоох зорилгоор холбогдох байгууллага, мэргэжилтнээс мэргэжлийн зөвлөгөө авах;

3.12.4.хөдөлмөрийн арбитрын хуралдаан явуулах байршил, хугацааг урьдчилан хэлэлцэн тогтоох, хуралдааныг цахимаар эсхүл хосолсон хэлбэрээр явуулах бол бэлтгэл хангуулах.

3.13.Хөдөлмөрийн арбитрын бүрэлдэхүүн байгуулагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор маргааныг шийдвэрлэнэ. Шаардлагатай бол хөдөлмөрийн арбитрч уг хугацааг нэг удаа ажлын 5 хүртэл өдрөөр сунгаж болно.

3.14.Хөдөлмөрийн арбитрын хуралдааныг хөдөлмөрийн арбитрын бүрэлдэхүүнээс сонгогдсон аль нэг хөдөлмөрийн арбитрч даргалж явуулна.

3.15.Хуралдааныг даргалагч хуралдаан эхлэх үед сонирхлын маргааны агуулгыг танилцуулна. Хуралдааны явцын талаарх тэмдэглэлийг аль нэг арбитрч хөтөлнө.

3.16.Хурал даргалагч нь маргалдагч талууд, сонирхлын маргааны агуулгын талаар хуралд оролцогчдод эхэлж танилцуулна. Үүний дараа талууд санал зөрүүтэй асуудлаар өөрсдийн байр суурь, үндэслэлийг ажилтны болон ажил олгогч талын төлөөлөгч тус тус танилцуулж чөлөөтэй хэлэлцэх боломжийг олгох хэлбэрээр хуралдааныг удирдан явуулна.

3.17.Хөдөлмөрийн арбитрч маргаантай холбоотой бичиг баримт, мэргэжилтнээс авсан мэдээлэл, зөвлөгөө зэргийг хуралдааны явцад маргалдагч талуудад танилцуулна.

3.18.Хуралдааны явцад маргалдагч талууд маргаанаа харилцан тохиролцож шийдвэрлэхээр тохиролцсон бол энэ тухай хуралдааны тэмдэглэлд тодорхой тусгана.

3.19.Хэрэв маргалдагч талууд сонирхлын маргаантай холбоотой мэргэжилтнээс туслалцаа авах эсхүл нэмж бичиг баримт гаргуулах хүсэлт гаргасан тохиолдолд ажлын 1 өдрөөс хэтрэхгүй хугацаагаар хуралдааныг нэг удаа хойшлуулж болно.

3.20. Хуралдаан хойшлогдсон тохиолдолд дараагийн хуралдааныг энэ дүрэмд заасны дагуу товлож явуулна.

3.21.Энэ дүрмийн 3.17-д зааснаар маргалдагч талууд сонирхлын маргаанаа харилцан тохиролцож шийдвэрлэхээр тохиролцсон бол хуралдаан дууссанаас хойш ажлын 2 өдөрт багтаан тухайн тохиролцоогоо бичгээр үйлдэн маргалдагч талуудын төлөөлөгчид гарын үсэг зурна.

3.22.Хуралдааны явцад энэ дүрмийн 3.20-т заасны дагуу маргалдагч талууд харилцан тохиролцсоноос бусад тохиолдолд хөдөлмөрийн арбитрын бүрэлдэхүүн хууль тогтоомжийг баримтлан сонирхлын маргааныг эцэслэн шийдвэрлэнэ.

3.23.Хөдөлмөрийн арбитр нь холбогдох бичиг баримт, дүгнэлтийг бүх талаас нь судалж, маргалдагч талуудын үндэслэл, шаардлагыг сонссоны дараа зөвлөлдөж, олонхийн саналаар шийдвэр гаргана. Хөдөлмөрийн арбитрч нь арбитрын хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар шийдвэр гаргахад түдгэлзэх эрхгүй. Маргалдагч талууд хоорондоо эвлэрсэн эсхүл хөдөлмөрийн арбитрын шийдвэрлэх маргаан мөн эсэхийг хэлэлцэж энэ талаар шийдвэртээ тусгана.

3.24.Энэ дүрмийн дагуу хөдөлмөрийн арбитрын бүрэлдэхүүн хуралдаанаараа маргааныг эцэслэн шийдвэрлэхдээ маргалдагч талуудыг байлцуулахгүйгээр нууц санал хурааж олонхийн саналд үндэслэн шийдвэр гаргана.

3.25.Хөдөлмөрийн арбитрын хуралдаан дууссаны дараа гаргасан шийдвэрийг маргалдагч талуудад сонсгох бөгөөд хуралдаан дууссанаас хойш ажлын 2 өдрийн дотор шийдвэрийг бичгээр үйлдэж маргалдагч талуудад хүргүүлнэ.

3.26.Хөдөлмөрийн арбитр хуралдаанаар маргааныг шийдвэрлэсэн талаарх шийдвэр гаргаснаар сонирхлын маргааныг хөдөлмөрийн арбитраар хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болно.

3.27.Хөдөлмөрийн арбитр нь хуралдаан болон тухайн сонирхлын маргаан шийдвэрлэхтэй холбоотой бусад үйл ажиллагааны тухай дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө.

Дөрөв. Хөдөлмөрийн арбитрын шийдвэр, түүний хэлбэр, агуулга

4.1.Хөдөлмөрийн арбитрын шийдвэрийг монгол хэлээр, бичгээр үйлдэж, хөдөлмөрийн арбитрын бүрэлдэхүүнд томилогдсон арбитрч тус бүр гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

4.2.Хөдөлмөрийн арбитрын шийдвэрийн агуулга нь маргалдагч талуудын хөдөлмөрийн арбитрад хандсан сонирхлын маргааны хүрээнд гарна.

4.3.Хөдөлмөрийн арбитрын шийдвэр нь доор дурдсан агуулгатай байна:

4.3.1.хөдөлмөрийн арбитрын бүрэлдэхүүн, уг бүрэлдэхүүнийг томилсон шийдвэрийн огноо;

4.3.2.маргалдагч талууд тэдгээрийн төлөөлөгчдийн нэр, сонирхлын маргааны үндсэн агуулга, хамрах хүрээ, хамтын гэрээ болон хамтын хэлэлцээрийн төслийн заалт;

4.3.3.хөдөлмөрийн арбитрын хуралдааны явцын талаарх хураангуй;

4.3.4.нотлох баримтын хураангуй (шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллага, мэргэжилтний дүгнэлтийн хураангуй);

4.3.5. Сонирхлын маргаантай холбоотойгоор хөдөлмөрийн арбитрын гаргасан шийдвэр.

4.4.Хөдөлмөрийн арбитр шийдвэр гаргаснаас хойш ажлын 3 өдрийн дотор шийдвэрийн хувийг аймаг, нийслэлийн хороонд хүргүүлнэ.

4.5.Хөдөлмөрийн арбитраар сонирхлын маргаан шийдвэрлэх явцад маргаантай асуудлаар маргалдагч талууд сайн дурын үндсэн дээр харилцан тохиролцоонд хүрсэн бол тохиролцоонд хүрсэн өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор тохиролцоог бичгээр байгуулж болно. Тохиролцооны хувийг хөдөлмөрийн арбитрад хүргүүлэх бөгөөд Хөдөлмөрийн арбитрын бүрэлдэхүүн уг тохиролцоог хөдөлмөрийн хууль тогтоомжтой нийцсэн эсэхийг хянан үзнэ. Тохиролцоог хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцэж байвал гэж үзвэл хөдөлмөрийн арбитрын шийдвэр гэж үзнэ.

4.6.Хөдөлмөрийн арбитрын шийдвэр нь сонирхлын маргааны хувьд эцсийнх байна.

4.7.Хөдөлмөрийн тухай хуулийн 151.6-д зааснаас бусад тохиолдолд маргалдагч талууд хөдөлмөрийн арбитрын шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргахгүй.

Тав.Хөдөлмөрийн арбитрч, маргалдагч талуудын эрх, үүрэг

5.1.Хөдөлмөрийн арбитрч нь Хөдөлмөрийн тухай хуулийн 152 дугаар зүйлд заасан эрх, үүргээс гадна дараах эрх, үүрэгтэй:

5.1.1.хөдөлмөрийн арбитрын үйл ажиллагаанд оролцохдоо үндэсний хорооны баталсан хөдөлмөрийн арбитрчийн ёс зүйн дүрмийг баримтлах;

5.1.2.маргаан шийдвэрлэхэд шаардлагатай гэж үзвэл холбогдох этгээдээс тайлбар авах, шаардлагатай баримт бичгийг маргалдагч талууд эсхүл холбогдох этгээдээс шаардах;

5.1.3.маргалдагч талуудын нууцыг хадгалах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

5.2.Маргалдагч талууд Хөдөлмөрийн тухай хуулийн 153 дугаар зүйлд заасан эрх, үүргээс гадна дараах эрх, үүрэгтэй:

5.2.1.хуралдааны явцад болон хуралдаан эхлэхээс өмнө сонирхлын маргаантай холбоотойгоор мэргэжлийн тайлбар, тодорхойлолт, шаардлагатай мэдээлэл, судалгаа гаргуулах хүсэлтийг хөдөлмөрийн арбитрт гаргах;

5.2.2.хуралдааны явцад эсхүл хуралдаан эхлэхээс өмнө сонирхлын маргаанаа хоорондоо эвлэрч зохицуулах;

5.2.3.маргаантай холбоотой баримт бичиг нэмж гаргах;

5.2.4.хөдөлмөрийн арбитрыг хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх үйл ажиллагааны журам зөрчсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах;

5.2.5.маргааныг зохицуулах, шийдвэрлэх эрмэлзэлтэйгээр хөдөлмөрийн арбитрын үйл ажиллагаанд оролцох;

5.2.6.Сонирхлын маргааныг зохицуулах, шийдвэрлэхэд шаардлагатай мэдээлэл, судалгаа, баримт бичгийг хөдөлмөрийн арбитрт гаргаж өгөх;

5.2.7.хөдөлмөрийн арбитрын бүрэлдэхүүнд багтсан арбитрчдын аль нэг нь тухайн маргаантай холбоотой ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж байгаа бол энэ тухай хөдөлмөрийн арбитрыг томилсон этгээдэд хандан тухайн арбитрчаас татгалзах тухай хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх.

Зургаа.Хөдөлмөрийн арбитрын удирдлага, санхүүжилт

6.1.Хөдөлмөрийн арбитрын удирдлагыг улсын хэмжээнд Үндэсний хороо, аймаг нийслэлийн хэмжээнд аймаг, нийслэлийн хороо хэрэгжүүлнэ.

6.2.Хөдөлмөрийн арбитрын үйл ажиллагааны зардлыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад тусгаж санхүүжүүлнэ.

6.3.Хөдөлмөрийн арбитрын зардлын зарцуулалтын талаар аймаг, нийслэлийн хороо тайлангаа сар бүрийн эцэст хүргүүлж Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу сар, улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээнд нэгтгэн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.4.Аймаг, нийслэлийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөдөлмөрийн арбитрын үйл ажиллагаа явуулахдаа холбоотой дараах үүрэгтэй:

6.4.1. хөдөлмөрийн арбитрын хуралдаан зохион байгуулах, товлох зэрэг ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэж, Хөдөлмөрийн арбитрын ажиллагааг явуулахад захиргааны болон техникийн бусад дэмжлэг үзүүлэх;

6.4.2.сонирхлын маргаан шийдвэрлэсэн тухай мэдээллийн санг бүрдүүлэх;

6.4.3.арбитрчдын нэрсийн жагсаалт болон арбитрчдын бүртгэлийг хөтлөх;

6.4.4.хөдөлмөрийн арбитрын үйл ажиллагааны талаар хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хөдөлмөрийн арбитрын үйл ажиллагааны тайланг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдөрт багтаан хүргүүлэх;

6.4.5.арбитрын үйл ажиллагааны төсвийн зарцуулалтын тайлан болон төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гаргаж эрх бүхий байгууллагад хүргүүлэх.

---oOo---